

БАТЛАВ.
ЦССҮТ-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР

2024 оны 05 сарын 15-ны өдөр

1118266548 9128905

“ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ УДИРДАМЖ

Сэдэв: Амьдрал бэлэглэсэн 20жил: Цусны донор танд баярлалаа!

2024 оны 05 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Зорилго:

Сайн дурын, авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэн, донорын үйлсийг сурталчлах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тогтмол хугацаанд цусаа бэлэглэдэг байнгын донор, байгууллага хамт олныг алдаршуулан талархал илэрхийлж, цус, цусан бүтээгдэхүүний хүрэлцээтэй нөөцийг бүрдүүлэхэд оршино.

Зорилт:

1. Бүх нийтийг хамруулан сурталчилгаа, талархал хүндэтгэл арга хэмжээ зохион байгуулж өргөн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэх;
2. Хүндэт донор, тогтмол хугацаанд цусаа бэлэглэдэг байнгын доноруудад талархал илэрхийлэх, алдаршуулах;
3. Цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулахад хамтран ажиллаж буй үндэсний болон олон улсын байгууллага, түншүүдийг дэмжих;
4. Сайн дурын болон хүмүүнлэгийн байгууллагын төлөөлөгч нарыг оролцуулсан сургалт, сурталчилгааны зурагт хуудас, нугалбарыг нийтэд түгээх;
5. Цусны донорын сайн үйлсийн аян өрнүүлэх;
6. Улаан, шар өнгө бүхий бэлэг дурсгалын зүйл хийлгэж түгээх;
7. Цусны доноруудын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийг боловсрол олгох, тэднийг тогтмол хугацаанд цусаа бэлэглэх орчин нөхцөлийг бүрдүүлэх;
8. Нийгмийн цахим сүлжээг ашиглан цусны доноруудын хандивласан цус, цусан бүтээгдэхүүний ачаар байнгын цус сэлбүүлэх шаардлагатай өвчөтнүүд амь нас аврагдсан тухай бодит түүхийг танилцуулах, үүгээр дамжуулан цусны доноруудыг идэвхжүүлэх зэрэг болно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага болон Олон улсын бусад байгууллагуудын хамтран гаргасан уриалгыг дэмжин орон даяар Цусны донорын Дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхийг уриалах;
- Цусны донорын Дэлхийн өдрөөр Хүндэт донор, цусны донорууд, цусны донор хамт олон, цусны донорын хөдөлгөөнийг дэмжигч байгууллагууд, иргэд олон нийтийг оролцуулсан хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах;

- Хөтөлбөр гарган арга хэмжээ зохион байгуулж, доноруудыг алдаршуулах, арга хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулах, сурталчилах;
- Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвүүд цусаа бэлэглэж байгаа доноруудад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- Цусны донорын талаарх мэдээлэл бүхий санамж, зөвлөмж, зурагт хуудас бусад материалыг бэлтгэн боловсруулж, хэвлүүлэх, түгээх;
- Донорын сургалт сурталчилгаанд олны танил хүмүүсийг татан оролцуулж, олон нийтийг донорын үйлсэд уриалах;
- Цусны донорын дэлхийн өдрийн уриа, удирдамжийг Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвүүд, цахим орчинд байршуулж олон нийтэд мэдээлэх, сурталчилах;
- Донорын сургалт сурталчилгаанд сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх.

Санхүүжүүлэгч байгууллага:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
2. Цус сэлбэлт судлалын үндэсний төв
3. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэн

Хэрэгжүүлэгч байгууллага:

1. Эрүүл мэндийн яам
2. Цус сэлбэлт судлалын үндэсний төв
3. Цусны салбар төв
4. Монголын Улаан загалмай нийгэмлэг
5. Монголын донорын холбоо

Хугацаа:

2024 оны II-III улиралд

Гарах үр дүн:

- ДЭМБ-ын хэрэгжүүлж буй ЦДДӨ-ийн уриа, удирдамжийн хэрэгжилт хангагдана.
- Цусны донорын талаарх сургалт сурталчилгааны мэдээллийн бааз нэмэгдэнэ.
- Хүн амын дунд цусны донорын талаарх мэдлэг, хандлага сайжирна.
- Цус цусан бүтээгдэхүүний байнгын нөөцийг бүрдүүлэхэд тодорхой нөлөө үзүүлнэ.

Боловсруулсан:

Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч  /Б.Ижилбаатар/

“ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨР”-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
УРЬДЧИЛСАН ХӨТӨЛБӨР

ЦДДӨ-ийг сурталчилах үйл ажиллагаа:

ДЭМБ-аас гаргасан уриалга, зөвлөмжийн чиг хандлагыг өөрийн орны онцлогт тохируулан мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээн сурталчилах

ЦССҮТ-ийн танилцуулга мэдээлэл, цусны донорын үйл ажиллагаа сурталчилсан цуврал видео контент болох Дорго 1. 2. 3. 4. 5. богино хэмжээний видеог олон нийтэд танилцуулах

Хүндэт зочдын төлөөлөл:

МУ-ын Засгийн газрын гишүүн, ЭМ-ийн сайд, МУЗН-ийн Ерөнхийлөгч, МДХ, сайн дурын байгууллагууд


Цусны донорыг алдаршуулан урамшуулах үйл ажиллагаа:

2024 онд шинээр “Хүндэт донор”-ын болзол хангасан донорууд, хамгийн залуу хүндэт донор, хамгийн олон өгөлттэй донорт шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа

2024 оны цусны донор хамт олон, шилдэг элсүүлэгч, цусны донорын үйлсийг дэмжигч шилдэг хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг номинацуудын шагнал олгох

Боловсруулсан:

Нийгмийн эрүүл мэндийн ажилтан

 /Д.Дулмаа/